# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ /ШИНЭ/

Засгийн газрын агентлагийн эрх зvйн байдлын тухай хуулийн 8 дугаар зvйлийн 8.4 дэх заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зvйлийн 6.1 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2012 оны “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны vйл ажиллагааны хотолбор батлах тухай” 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны ”Үйл ажиллагааны хотолборийг хэрэгжvvлэх толовлогоо батлах тухай” 120 дугаар тогтоолын 122.1, 162.1 дэх хэсгийг тус тус vндэслэн ТУШААХ нь:

1.“Байгууллагын vйлчилгээний стандарт”-д хогжлийн бэрхшээлтэй иргэдийн vйлчлvvлэх эрхийг хангах, тэдний нийгмийн оролцоо, идэвхийг нэмэгдvvлэх зорилгоор дор дурдсан агуулга бvхий нэмэлт оруулсугай.

“ 6. Ажлын байранд тавих шаардлага, тэмдэг, тэмдэглэгээ

1.4. Нэг налуу замын орголтийн ондор 800 мм-ээс, налуугийн онцог 1:12-оос ихгvй, 200 мм-ийн ондорт гарах бол 1:10-аас ихгvй, хондлонгийн налуу 1:50-аас хэтрэхгvй байх ёстой. Налуу замын болон талбайн гадна хvрээний далангийн ондор 50 мм-ээс багагvй байна. /MNS 6055:2009/

1.5. Налуу замын эхлэл, тогсголд тэгш талбай байгуулах ба тvvний урт нь налуу замын оргоноос багагvй буюу 1500 мм-ээс багагvй байна. Налуу замын чиглэл оорчлогдох тохиолдолд тэгш биш талбайн оргон нь тэргэнцэр эргэх боломжтой байх ёстой. /MNS 6055:2009/

1.6. Налуу замын хоёр хажуу талаар 900 мм-ээс багагvй ондорт бариул бvхий хашлага хийнэ. Бариулыг хоёр эгнээгээр байрлуулж, тэдгээрийн ондор нь 700 мм ба 900 мм байна. /MNS 6055:2009/

1.7. Хараагы бэрхшээлтэй хvнд зориулж vйлчилгээний заал,ороо, тасалгааны

гэрэлтvvлэг хамтатгасан байж болно. Ойлтын коэфицентоос хамаарч vйлчилгээний заал, ороо, тасалгааны болон тоног тохооромжийн гадаргуу дээрх сул /бvдэг/ онгийн ойлтын эзлэх хувь дараах байдалтай байна. Yvнд тааз 70%, хана 60%, дээд доод бvс 50%, тоног тохооромж 35%, шал 25%-иас 30% байна. /MNS 6055:2009/

1.8. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж мэдээллийн самбар дахь мэдээллийг ARIAL MON 16 vсгийн фонтоор хэвлэж байршуулна.

1.9. Сонсголын бэрхшээлтэй хvнд зориулсан чанга тод дуутай микрофон ашиглана.

1.10. Хогжлийн бэрхшээлтэй иргэдэд vйлчилгээ vзvvлэхэд дараах тэмдэг, тэмдэглэгээг ашиглана.

1.10.1. Харааны бэрхшээлтэй иргэдэд vйлчлэх цонхны тэмдэглэгээ



1.10.2. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд vйлчлэх цонхны тэмдэглэгээ



6.10.3. Ходолгооний бэрхшээлтэй иргэдэд vйлчлэх цонхны тэмдэглэгээ



“8. Үйлчилгээний ажилтан vйлчлvvлэгчтэй харилцах харилцаанд тавих шаардлага

8.11. Үйлчилгээний ажилтан хогжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээг ойлгон хvндэтгэлтэй харьцана.

8.12. Хогжлийн бэрхшээлтэй иргэд vйлчлvvлсэний дараа дахин туслах зvйл байгаа эсэх талаар vйлчилгээний ажилтан асууж хэвшинэ.

8.13. Үйлчилгээний ажилтан нь хогжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, ондор настай /70-аас дээш/ иргэдэд дараалал харгалзахгvй vйлчилж болно.

8.14. Улсын бvртгэлийн vйлчилгээ vзvvлж байгаа нэгж тус бvр 1-2 албан хаагчийг дохионы хэлний мэдлэг эзэмших сургалтанд хамруулсан байна.

“9. Үйлчилгээний vед хориглох vйлдлvvд

9.6. Үйлчилгээний ажилтан хогжлийн бэрхшээлтэй иргэдийг vл тоомсорлох, тэднийг дооглох, оровдож харилцахыг хориглоно.

9.7. Албан хаагч нь vйлчлvvлэгчийг жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

2. Энэхvv тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын vvргийг тvр орлон гvйцэтгэгч С.Алтангэрэл, vйл ажиллагаандаа мордлог болгон ажиллахыг нэгжийн дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ц.ПҮРЭВДОРЖ